

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХУУЛЬ ХЯНАЛТ, ШҮҮХ, АРБИТРААР ШИЙДВЭРЛЭГДЭЖ БУЙ ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ /2024 ОН/

№	Хэргийн харьяалал	Хэргийн оролцогч	Нэхэмжлэлийн шаардлага	Хэрэг шийдвэрлэгдсэн байдал
1	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: “Апекс ван хөгжил” ХХК	2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр MR-2021-03-290 тоот “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан 792.4 тонн флотацын жоншны баяжмал ФФ95Б худалдаж авсан бөгөөд гэрээний 10.3 заалтын дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр(АМНАТ)-ийг “Апекс ван хөгжил” ХХК төлөх үүрэгтэй байсан. Татварын байгууллагаас манай ТӨҮГ-аас АМНАТ 38,578,598.25 төгрөгийг суутгал хийгдсэн. Дээрх АМНАТ-д төлсөн 38,578,598.25 төгрөг, Арбитрын зардалд төлсөн 946,572 төгрөгийг “Апекс ван хөгжил” ХХК-с гаргуулж “Монголросцветмет” ТӨҮГ-т олгох тухай.	Арбитрын үндсэн хуралдаан 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр болж Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж Монголын олон улсын арбитрын 734 дугаар шийдвэр гарсан.
2	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Алтайн цаст уулс” ХХК; Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Монголросцветмет ТӨҮГ-ын сөрөг нэхэмжлэлтэй	Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байрлах MV-000174 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн төмөр замын бүсэд харьяалагдах 4,8 га газрыг “Алтайн цаст уулс” ХХК нь тэргүүн ээлжинд түрээслэх эрхтэй болохыг тогтоож, түрээсийн шинэ гэрээ байгуулах, хугацаа сунгахыг хариуцагч нарт даалгах тухай. “Монголросцветмет” ТӨҮГ-ын сөрөг нэхэмжлэл: 4.8 га газрыг чөлөөлүүлэх тухай сөрөг нэхэмжлэлтэй.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр болж Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн дугаар 101/ШШ2024/05001 шийдвэрээр “Алтайн цаст уулс” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, сөрөг нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.
3	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум	Нэхэмжлэгч: “Ньюланд пропертис” ХХК;	Үндсэн нэхэмжлэл: “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн эзэмшлийн газарт байрлах Адгийн ил уурхайн баруун	Хэнтий аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар Хэнтий аймгийн Бор-

	дахь сум дундын шүүх	Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ, харьяа “Бор- Өндөр” УБҮ нар. Гуравдагч этгээд: “Монро глобал” ХХК	талын координат /N46 17 45.2 E109 19 42.3/-д байрлах хаягдал хөрс чулуулгийн овоолгыг хууль ёсны өмчлөгчөөр тогтоож, хаягдал хөрс чулуулгийн овоолгыг зөөвөрлөхөд саад учруулахгүй байхыг даалгах; Сөрөг нэхэмжлэл: 2018 оны 10 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан bu-018-01-019 дугаартай ХХАГ-ээс татгалзсан Бор-Өндөр УБҮ-ийн татгалзал хуульд нийцсэн, үндэслэл бүхий болохыг тогтоож, “Нью ланд пропертис” ХХК нь Адагийн уурхайн баруун талын /N46 17 45.2 E109 19 42.3/ координатад байрлах хаягдал хөрс, чулуулгийн овоолгыг гэрээний дагуу ашигласнаар олсон ашиг болох 209,016,000 төгрөгийг буцаан гаргуулах; Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага: “Нью ланд пропертис” ХХК болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор- Өндөр” УБҮ-ийн хооронд байгуулсан bu-018- 01-019 дугаартай худалдах худалдан авах гэрээг цуцлагдсанд тооцуулж, “Монро глобал” ХХК-ийн “Монголросцветмет” ТӨҮГ-тай байгуулсан 2020.03.06-ны өдрийн MR-2020-02- 04 дугаартай хамтран ажиллах гэрээг хүчин төгөлдөрт тооцуулах тухай	Өндөр сум дахь сум дундын шүүхийн 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 157/ШШ2023/00043 дугаар шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 157/ШШ2024/00016 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Хариуцагч “Монголросцветмет” ТӨҮГ нь дээрх шийдвэрийг эс зөвшөөрч Хэнтий аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр давж заалдах гомдол гаргасан ба давж заалдах шатны шүүхээс гомдлыг хангаж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэхэмжлэгчийн зүгээс хяналтын шатны гомдол гаргасан ба 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Монгол улсын дээд шүүхийн иргэний хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны дугаар 001/ХТ2024/00230 тогтоолоор шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж нэхэмжлэгчийн гомдлыг хүлээн аваагүй нэхэмжлэлийн шаарлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
4	Сүхбаатар дүүргийн иргэний		“Жэй эм си” ХХК нь дампуурсанд тооцуулах тухай хүсэлттэй бөгөөд “Монголросцветмет” ТӨҮГ нь “Жэй Эм Эс Си” ХХК-г дахин	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дампуурлын хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж шүүх

	хэргийн анхан шатны шүүх	Хүсэлт гаргагч “Жэй эм си” ХХК Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: “Жэй эм эс си” ХХК	хөрөнгөжүүлэх саналтай байх ба тус компаниас 201,252,595.41 /хоёр зуун нэг сая хоёр зуун тавин хоёр мянга таван зуун ерэн таван төгрөг дөчин нэгэн мөнгө/ төгрөгийг гаргуулж “Монголросцветмет” ТӨҮГ-ыг хохиролгүй болгуулах тухай	хуралдаанаар дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгосон дугаар 181/ШЗ2024/14374 шүүгчийн захирамж гарсан бөгөөд “Жей эм эс си” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс захирамжид гомдол гаргасан боловч мөн шүүхийн тогтоолоор гомдлыг хүлээн аваагүй.
5	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: “Миг даатгал” ХХК	“Монголросцветмет” ТӨҮГ болон “Миг даатгал” ХХК нарын хооронд 2022 оны 06 дугаар сарын 20-ний өдөр байгуулсан MR-2022-06-14 тоот “Гэнэтийн ослын даатгалын гэрээ”-ний нөхөн төлбөрт 18,000,000 (арван найман сая) төгрөг, алданги 9,000,000 (есөн сая) төгрөг, нийт 27,000,000 (хорин долоон сая) төгрөгийг “Миг Даатгал” ХХК-иас гаргуулах тухай	СБДИХАШШ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 181/ШШ2024/00114 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Хариуцагч тус шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан ба тус шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 210/МА2024/00516 дугаар магадлалаар СБДИХАШШ-ийн 181/ШШ2024/00114 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж гомдлыг хангаагүй. Хариуцагч магадлалыг эс зөвшөөрч Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн тэнхимд гомдол гаргасан ба тус шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан.
6	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Баянтэгш импекс” ХХК Хариуцагч: “Монголросцветмет”	MR-2020-02-20 Хамтран ажиллах гэрээг хүчин төгөлдөрт тооцуулах, хохиролд 40600000 төгрөг гаргуулах, Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод аудитын дүгнэлтийг хүчингүй болгуулах тухай	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр шүүх хуралдаан болж дугаар 182/ШЗ2024/19904

		ТӨҮГ, “Эрдэнэс Монгол” ХХК,		захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
7	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Нью энерги стар” Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ	“Нью энерги стар” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Монголросцветмет” ТӨҮГ-т холбогдох 2022 оны 11 дүгээр сарын 2-ний өдөр байгуулсан MR-2022-03-240 тоот “Бараа худалдах, худалдан авах гэрээ”-ний үлдэгдэл төлбөр 1,133,263,070 (нэг тэрбум нэг зуун гучин гурван сая хоёр зуун жаран гурван мянга дал) төгрөг, алданги 300,167,898,72 (гурван зуун сая нэг зуун жаран долоон мянга найман зуун ерэн найман төгрөг далан хоёр мөнгө) төгрөг, нийт 1,417,430,968.72 (нэг тэрбум дөрвөн зуун арван долоон сая дөрвөн зуун гучин мянга есөн зуун жаран найман төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийг гаргуулах тухай	Талууд 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр MR-2024-06-03 тоот “Эвлэрлийн гэрээ”-г байгуулж Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 101/ШШ2024/01423 дугаар “Зохигчдын эвлэрлийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” захирамж гарч шийдвэрлэгдсэн.
8	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: Иргэн Б.Мөнхбат Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024.09.13-ны өдрийн 401 тоот тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж анхан шатны шүүхийн шийдвэр гарч нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.
9	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: Үндэсний аудитын газар, Санхүү нийцлийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг, аудитын	Үндэсний аудитын газрын 2024.03.25-ны өдрийн 152/A01500092 СНАГ-2024/30/НА-СТА-ТӨА дугаартай Төлбөр барагдуулах тухай актыг бүхэлд нь хүчингүй болгуулах тухай	2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан болж дугаар 128/ШШ2024/0867 шийдвэрээр Төлөр барагдуулах тухай актаар тавигдсан төлбөрийг 50 хувь бууруулж шийдвэрлэсэн.

		менежер Б.Долгорсүрэн, Б энд С аудит ХХК		
10	БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Баяннуур сумын Ардын дунд шатны шүүх	Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: “Inner Mongolia Bochen energy” Co., Ltd	БНХАУ-ын “Inner Mongolia Bochen energy” Co.,Ltd, Монголын Олон Улсын арбитрын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 952 дугаар шийдвэрээр нийт 83,079.5 ам.долларыг БНХАУ-ын “Inner Mongolia Bochen energy” Co.,Ltd гаргуулан нэхэмжлэгч “Монголросцветмет” ТӨҮГ-т олгохоор шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг хангуулах тухай	Арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэхээр өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг ӨМӨЗО-ны Баяннуур сумын ардын дунд шатны шүүхэд гаргаж тус шүүх дээр арбитрын шийдвэрийн хүрээнд анхан шатны шүүх хуралдаан болсон бөгөөд шийдвэр гүйцэтгэх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн боловч “Inner Mongolia Bochen energy” Co., Ltd гомдол гаргаад байна.
11	БНХАУ-ын Шанхай хотын Ардын дунд шатны шүүх	Нэхэмжлэгч: “Монголросцветмет” ТӨҮГ Хариуцагч: “Xizhou shanghai technology” Co., Ltd	БНХАУ-ын “Xizhou shanghai technology” Co., ltd- д холбогдох арбитрын хуралдаанд оролцсон бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэрээр нийт 228,484.88 ам.долларыг БНХАУ-ын “Xizhou shanghai technology” Co.,Ltd гаргуулан “Монголросцветмет” ТӨҮГ-т олгохоор шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг хангуулах тухай	Арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэхээр өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг БНХАУ-ын Шанхай хотын ардын дунд шатны шүүхэд гаргаж тус шүүх дээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх ажиллагаа хийгдэж байна.
12	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлал	Өргөдөл гаргагч: “Монголросцветмет” ТӨҮГ Уригдагч: “Соёолон групп” ХХК	“Соёолон групп” ХХК-иас талст тосны хүчил 9900 кг, шингэн шил 1032.5 кг, техникийн сод 8400 кг-ийг буцаан гаргуулах тухай	Шүүхийн эвлэрүүлэн зуучлагчаас “Соёолон групп” ХХК-д мэдэгдэх хуудас хүргүүлж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдаж Эвлэрлийн гэрээ байгуулагдсан ба шүүгчийн Дугаар 183/ШЗ2024/27237 захирамжаар тус гэрээг баталгаажуулсан

-----oOo-----